

www.e-pada.com

Адтай мятав

Нэг едер сонины эрхлэгч намайг дуудаж

-Чамайг томилолтоор хедее явуулж, Мятав гэдэг хвний турхай сурвалжлуулахаар боллоо. тэр хвн, саяхан шатаж байгаа таван давхар байшингийн тагтан дээрээс нэг хvvхдийг буулган авч амий нь аварсан байна гэлээ. Би “буулган авч гэнэ vv? Єерє дор нь байж байгаад шат тавьж єгсєн хэрэг vv?” гэж асуулаа. Эрхлэгч:ийм учиртай юм гэнэ. Үүдний єрєнєсєс нь гэнэт хvчтэй гал дvрэлзэн асахад найман настай жаал хvv яах ч аргаа ололгvй тагтан дээрээ зугатан гарчээ. Удалгvй хойноос нь харанхуй хар утаа хуйлран баагиж, юу ч vлдээлгvй хуйхлах гэсэн шиг улаан гар єрвєлзєн эрчилж, ve ve хvvхдийн биєнд хvрч байжээ.

Гудамжинд цугларсан хvмvvс хий дэмий “Хаалга нь дотроосоо тvгжээтэй юм. Одоо яана аа. Бусад нь дvvрч, тэр хvvг л авах юмсан, шат байгаад хvрэхгvй нь, Юун ч єндєр юм бэ” гэх зєргээр учир замбараагvй шуугилдаж юу хийхээ мэдэхгvй самгардан бужигналдсан гэнэ. Гэтэл Мятав тэдэн дээр ирж, байдлыг мэдмэгч манайхаас урт олс аваад ир гэж хvvхэд гvйлгєжээ. Бvх хvмvvсийн найдвар гагцхvv Мятавт хандаж тvvний хэлэх, хєдлєхийг л харцгааж байжээ. Хvvхэд олс авчирмагч Мятав vзvvрийг дээш шидэж, тэвдэж сандарсан хvvд:

-Тайван бай. Олсны vзvvрээр биеє ороон сайн барь. Тэгээд доошоо всэр! гэлээ. Хvv ч заасан ёсоор нь всэрчээ. харж зогссон хvмvvс цєм дуу алдацгаав. Мятав хvvг всэрмэгц хvчий нь дагуулан олсоо хvчтэй эргvvлжээ. Олноос зуурсан хvv гайхан шуугилдаж байсан хvмvvсийн толгой дээгvvр Мятавын гарын аясаар эргэлдэж гарчээ. Тэгснээ Мятав эрчи нь бууруулан бууруулсаар хvvг дэргэдээ буулгаж авсан гэнэ.

“Хачин юм даа” гэж намайг дуу алдахад эрхлэгч

-Нээрээ тун сонин юм шvv. Би дуулснаа л чамд ярьж єглєє. Сайн сурвалжилбал єєр юм ч олдож магадгvй гэсэн юм. Ингээд би Мятав гуайг эрэн сурвалжлахаар хvлгийн жолоог хедее тийш нь заллаа.

Надтай хуучилж суугаа хvнийг Баяр гэдэг юм. Тэр, хашир хянуур, нягт нямбай, vг дуу цєєнтэй ч vнэн яриатай, єргєн мэдлэг, арвин туршлагатай, нутаг усныхандаа vлгэрч тvvхч гэж алдаршсан хvн.

Баяр гуай нутаг орныхоо тvvх, уул усны домог, тэндээс терсэн алдар цуутнуудын тухай олон юм мэднэ. Тиймээс ч би Баяр гуайг Мятавын сонин явдал руу нэвтрэн

орох “гvvр”, эрлийн эхэн болж чадах хvн гэж найдан, хэрэг болгож зорьж ирсэн юм.

-Та Мятав гэдэг хvнийг таних уу? гэж би шууд яриа едлээ.

-Адтай Мятав уу? Би сайн танина. Дотор сайтай, ухаан сийрэг, цэцэн цэлмэг хvн юм шvv дээ гэлээ.

Тэгвэл тэр хvнийхээ тухай надад нэг сайн ярьж өгөөч. Тун их хэрэг болоод байна гэвэл,

-Ажил вйлсий нь ярих юм уу. Авир терхий нь хэлэх юм уу гээд инээмсэглэнэ.

-Аль, алиныг нь... гэж би дуу алдав.

Баяр гуай-Манай нутгийнхан тvvнийг адтай Мятав, ачтай Мятав гэдэг юм. Нэг ve манайхан бишгvйдээ л айл аймаг явдаг байлаа. Хатирдаг морь, хэцvv ан, сайхан айрганд дуртай, нутаг усныхандаа нэр тер сайтай, делгеен сайхан зантай, тусархуу, ажилсаг, эртгч, наргиан, хөгжөөнтэй, хедее нутагт олон тааралдах жирийн л нэг гvдэс шулуун хvн дээ. Овор терхий нь яривал, унжуудуу хамар, урт эрvvтэй, сэргэлэн хурц нvдтэй, амьдралын олон он жилийн хугацаанд хал дол vзсэнийг гэрчлэх мэт хэдэн гvн vрчлээ суусан ерген магнай, тэгш сайхан шvд бvхий цээж тэвхгэр зузаан, залуудаа сайхан эр явсан болов уу гэмээр янхигардуу чацархаг биетэй, хенген шингэн нэг vгээр хэлбэл, нvдэнд дулаахан сайхан өвгөн байдаг гэдгийг л би сайн мэдэх юм.

Мятав сvvлийнхэнтэйгээ нэг хэсэг нэгдлийн хонь хариулж байлаа гэсэн. Хеделмерийн баатар болоогvй ч мал маллахын эрдэм ухааны сайн мэддэг, нэгдлийн урдаа барьдаг хоньчны нэг гэгдэж, сонин хэвлэлд ч гарч байсан байхаа.

-Хvний байдал ерөнхийдөө ийм байж. Ажил хэргээс нь?...гэж намайг шамдуулахад Баяр гуай сахлаа имэрч:

-Ах чинь vнэрхэж байгаа юм биш. Үлгэр домог бол яриад л өгөхсөн. Буух эзэнтэй буцах замтай юмыг тэгж болохгvй ээ. Мятав гэдэг чинь vлгэр домгийн баатар биш, жинхэнэ эгэл жирийн хvн шvv дээ гэж инээмсэглээд,

-Чи эхлээд хоршооны манаач Ёлзийтэй уулз. Мятав Ёлзий хоёр чинь цуг дайтаж явсан улс. Тэр чамд мундахгvй юм хэлж ч өгнө. Хэнтэй уулзахыг зааж ч чадна гээд тамхиа сорж хэсэг сууснаа горьдсон гуйсан нvдээр өөрий нь ширтэн суугаа намайг харж өрөвдсөн бололтой.

-Чи өр нь салахгvй шинжийн эр vv дээ. Үзэж дуулсан ганц нэг юмаа ярьж vзэхээс дээ хэмээн бүдэгхэн шивнэж хойно өгvvлэх хоёр явдлыг ярьж өгсөн юм.

Ийнхvv эрэл маань бvтэмжтэй эхэллээ.

НЭГЭН СЭХЭЭ

Олон нуурын голд Хэцүү цvнхээл гэж зард гарсан бэрх нуур байдаг юм. Томоороо ч гавихгvй л дээ. Нэг захаасаа нөгөө захаа хvртэл ердөө зуугаадхан л алхам. Жижигхэн хэрнээ учиргvй гvнзгий, эргvллэгтэй, дотор нь орсон хэрийн амьтан эсэн мэнд эргэж гарах нь ховор дуулддаг. Уг нь ус нь тунгалаг тогтуун делгеен, ёроолын шаргал элс нь тун ойрхон мэт туяаран харагддаг. Дэргэдvүр нь янз бүрийн өвс ургамал алаглан ургасан, хажуухандаа нарийн ширхэгтэй зөслөн элстэй, ёстой л амарч байгууштай сайхан газар байдаг юм.

Зургаан сарын аагим халуун ид шатаж байсан ve юмсан. Мятав хонь салхидаад хэцүү цvнхээлд вйчих вий, юмыг яаж мэдэх вэ гэсээр нуурын хойд ухаа дээгvүр гарч иржээ. Гэтэл бачимдсан хvний муухай орилох дуу гарч гэнэ. Тогтож харвал, нуурын усанд нэг хvн орчихсон ve ve шовсхийн, сарвалзаж байгаа vзэгдлээ. Мятав нэг мэдэхнээ нуурын эрэг дээр ирчихсэн, “Одоо яана аа сvйд боллоо. Нуур луу орчихоор хамт өнгөрчих, гарч нь бариулчих гэхээр юу ч байдаггvй” гэж гаслан зогсож байв.

Ядаж уснаас их айдгийг хэлэх vү, яадаг ч аргаа олохгvй нэг хэсэг болжээ.

Нөгөө хvн нэг ил гарч, нэг адлд орж орь дуу тавьсан хэвээр. Дууны нь хvч улам суларч байхыг vзээд бvр ч их бачимдсан гэнэ. Улс амьтанд дуулгая уу гээд эргэтэл тэвдсэндээ болоод морио алдчихсан хөл залгаж хэл хvргэх унаа бvү хэл, гартаа барьсан шидэмсний тасархай ч гvй хоцорсон байжээ.

Яана аа, өнгөрчихлөө л дөө гэж харамсан ийш тийшээ хартал бөөр алаг хvрэн бяруу нь оодогнон сvүл хатгасаар айсууг vзэнгvүт:

-Тэгдэг хэрэг, болдог арга! гэж дуу алдан бярууг амдлаа. Ялаа шумууланд хөөгдөн ухаан жолоогvй яваа бярууг ойртоод ирэхээр нь ухасхийн сvүлдэж барьж аваад тэврэн нуур луу гvйв.

Нуурын эрэг дээр ирж, нөгөө хvний ил гарч ирэхийг отож байснаа байдаг чадлаа шавхан бярууг нуурын тэг дунд чулуудчихлаа. Холхийх сvүртэй чимээ гарч, Мятав цалгисан усны хvчит давалгаанд цохигдон ар тийшээ саван унажээ.

Долгио намдахаар эргэн тойрноо харсан чинь нөгөө хvн тэртээ эргийн шаргал элсэн дээр хэвтээ харагдлаа. Очтол нөгөө хvн амьсгаа авч жаахан уужраад,

-Ус элч хоёрт vхэх шахлаа. Юу ч болов доо. Усанд сарваганаж явтал минь нэг хvн том алаг юм чулуудчих шиг болсон. Тэгсэн чинь ус хvчтэй палхийгээд би тvүнээс vүссэн хvчтэй долгионд цохигдон шидэгдэж яаж ч чадалгvй элс рvү шаачихаад бvтэж vхэх шахлаа гэхэд,

-Арай дэндvү хvчтэй шидчихсэн юм болов уу даа. За яамай, яамай. Эрдэнэт хvний амь л мэнд гарсан бол болох нь тэр! гэж Мятав олзуурхан баярлаж суужээ.

Хvний золионд амь алдах шахсан бярууны хошуу ve ve цухалзан явсаар нуурын эрэг рvv огло харайн гарч усаа шилгээгээд ингэж сэrvvцдэг бол ч аюултай юм байна гэсэн янзтай эзэн рvvгээ харж байснаа ижлээ vгvйлэх мэт меерен гэрийн зvг шогшиход Мятав:

-Ингэх л ёстойсон. Овоо шvv бээр алаг минь. Монгол vxрийн эрдмийг ёстой нэг vзvvлж чадлаа даа гэж бахдан хайрлажээ.

ХУСНЫ ШИД

Нэг едер Мятав малд явж байгаад Асгатын цохион дээрээс хэдэн тэмээгээ дурандаж суужээ. Тэр цохио бол хажуунаас нь хус мод шахан ургасан, гурав дөрвөн давхар байшингийн дайтай, тэрvvхэндээ ендер гээчийн газар байдаг юм. Хvржигнэх свртэй дуу гарахаар Мятав эргээд харсан чинь том алаг ирвэс ард нь ирчихсэн хэдхэн алхмын цаанаас всрэн дайрахаар завдаж байлаа.

Хаашаа ч гарах газаргvй болжээ. Ирвэс биеэ хураан архирлаа. Мятав гэнэт цохионоос всэрч ендер хусны оройгоос зуурахад хус саван гулзайж нумарсаар Мятавыг газардуулав. Ирвэс хойноос нь всрэхээс айн зvрхшээсэн янзтай ендер хадны ирмэг дээр ирчихсэн балтайн хярж, Мятав руу хий л гелерч байв. Мятав “чамайг одоо” гэж шивнэн арайхийн тогтоон барьж байгаа нумарсан хусны vзvvрийг ирвэс рvv чиглvvлэн татаж байгаад тавьчихав. Хусны vзvvр чавхдан очиж ирвэсийг шавхуурдахад огцом муухай дуу гарч, амь тавьсан ирвэс ендер хаднаас цоохор арьс шидсэн мэт газарт нэвсийн унажээ.

Ингэж Мятав халз тулгарсан араатны аюулаас ухаанаараа мултран гарсан тvvхтэй.

Би тэгээд манаач Слзий гуайтай уулзсан юм.

-Та найзынхаа тухай ярьж егнe vv гэвэл:

-Селех юмгvй таван хуруу тэгш хvн. Хvний хийдгийг л хийдэг хvн дээ. Илvv гарна уу гэхээс дутна л гэж лав vгvй.

-Яагаад адтай Мятав гэж хэлэгддэг болсон юм бэ?

-Яах вэ ажил вйлс, авхаалж самбаа нь хvн хvнээс гоц тасархай болохоор л тэгж нэрлээ биз.

-Та тэгвэл ажил вйлсээс нь ярьж егееч.

-Ах чинь бvгдийг нь мэдэхгvй. Улс амьтан янз янзын л юм ярьдаг юм. Би дайтаж явсан цагийнх нь явдлаас зарим юмыг еереер нь яриулж, соронзон хальсанд бичиж авсан юм. Тvvнийгээ л шууд сонсгочихье. Чамд Мятавын явдал тийм хэрэгтэй юм бол Менхтэй уулзаарай л даа. Тэднийх одоо Борын хендид зусаж байгаа болов уу.

Мөнх Мятав хоёр бас ч ягтвй дотно, хэн хэнийхээ ажил явдлыг овоо гадарладаг л баймаар улс даа. Арай хоосон буцаахгвй байх гээд дуу хураагчийнхаа товчийг дарахад хэн нэгний эрдvv боргил хоолой сонсогдож намайг гялайлгасан билээ.

ГАЙХАМШИГТ СОРОНЗОН

Эх орны минь эрх чөлөө, тусгаар тогтнолд гадны аюул заналхийлсэн тvгшvүртэй цаг ve байлаа. Дайсан манай хил рvү ve ve гэнэт уулгалан дайрч едсөн хатгаж байсан юм.

Цэрэг болгон л дайн дажин, будлиан самуун, vxэл хагацал, ялсан дийлснээ ярьдаг байлаа. Шинэ цэрэг миний хувьд бол урьд өмнө ямар нэг вймээн будлианд оролцож явсангвй. Хvмvүсийн ярихыг сонсож суухад нэг ve тун ч аюултай юм шиг, нэг бодоход авхаалж самбаатайхан vзэлцвэл харин гавъяанд хvрч болмоор ч юм шиг, нэг vгээр хэлбэл, айж нэг vзэж, атаархаж нэг vзэж явсан цаг.

Намайг харуул манаанд гарсан хугацаанд юу ч тааралддаггвй байсан болохоор битvүхэндээ бардамнах маягтай. ""гвй ер нь яадаг юм бэ? Цеевтер дайсан ирвэл ирэг. Хурдан буу vүрсэн эр хvн байна даа, vзэлцээд авахад яадаг юм бэ. Сэхээ самбаатай уужуухан байлдвал дийлж бололгвй дээ” гэж боддог байж билээ.

Нэг едер дөрвvүл манаанд гараад байтал дайсны машин дvүрэг цэрэг гэнэт гарч ирээд тарж хэвтэцгээлээ. Манай дарга нэг нөхрөө холбоо бариулахаар анги руу буцаалаа. Би тэгэхэд “Ашгвй намайг явуулаагвй нь яамай. Одоо л vзэж алдахгвй юм бол хэзээ цэргийн сургууль эрдэм хийснийхээ хэргийг гаргах юм бэ. За хеерхий чиг сум тоолж өгнө дее. Хорь гараадхан хvн ч юуны олон байх вэ дээ. Баатар болдоггвй юм гэхэд хариад нутаг усныхандаа ярих юмтай болж авъя. Эхлээд даргы нь нухаад авдаг хэрэг ээ гэж бодоод битvүхэн баярласан юм шиг тушаал хvлээн анаж хэвтлээ.

Гэтэл дайсны талаас буу тасхийн, газар доргин, яих дvлийрч нvд харанхуйлаад явчих нь тэр. Арай гэж харахад дайсны бууны ам харлан яг л амин газар руу шивчих гэж байгаа юм шиг vзэгдлээ. Хаагуур сум орчихдог бол гэхээс хуйх хөндvүрлэж, нурууны хvйтэн хөлс чийхарна. Дахин дахин буус тасхийн, толгойны үс хуйхалчих шиг боллоо. Яана даа, хэцvүдэх нь. Босоод зугатах юмсан гэж дарга руугаа харсан чинь тэр ер сандарсан шинжгвй дайсан руу заналтайяа ширтэж байлаа.

Миний айж байгааг гэдэг зvйрлэж хэлэхийн аргагвй. Ингэж байгаад дайсны бууны идэш болох вий гэхээс ясны хөлс дааварлаж, ойр хавь оготны нvх байдаг бол багтаад орчихоор санагдана. Эргэн тойрныг харахад хvний бие халхлах байтугай могойны зулзага нуугдах газаргвй, нvцгэн цагаан тал байх шиг бодогдож, арга ядан дахин ахлагч руугаа хартал хөмхийгөө зуусан хэвээрээ, “Доошоо хэвт!” гэж дохиж байв.

Хvний санаанд ганцхан агшинд хорвоо дэлхий бvүхлээрээ багтдаг хойно доо. Би ч

олон юм бодож амжлаа. Тулалдах гэдэг чинь юутай ч зүйрлэхийн аргагвй аюул юм даа. Энэ даргын ойртуулах гээд тайван байгаа, миний байж байгаа хоёр таарч дээ. Ээ гэгээн терийн минь сүлд, яаж нэг мэнд гарья даа хэмээн бодож хавчигнан, ёстой тушаалын эрхээр газарт наалдаж байлаа.

Буу дахин тас тасхийн хоёр чих шуугин, толгойн янгинаадз хамаг биеийн мэдээ алдрах шиг боллоо.

-Одоо ч тэсэхээ байлаа шүү хэмээн шивэгэж биеэ тэмтэрч үзэв. Дайсны ойртож байгаа гэдэг ч яриа алга. Бараг хүний зүс танигдахаар боллоо.

-Эргээд зугт гэж гялайлгадаггвй юм болов уу гэж бодсоор дарга еедее дахин хартал, нүднийхээ булангаар сүртэй нь аргагвй хялавхийгээд дайсны зүг хэмхийгее зуун ширтсээн. Негее нехер маань огт тэвдэж сандарсан шинжгвй, мелхеж байгаа дайсныг бүртгэх мэт харсаар.

Миний энд л хэцүү газар таарч дээ. Ер нь би үхлийн шороо пурхийх газраа л олж хэвтснээс зайлахгвй. Даргын дэргэд ч очиж болдоггвй байгаа даа. Тэгвэл немер түшигтэй, айхгвй буудалцаж болох байх шүү. Дарга намайг дуудахгвй, мөн хатуу сэтгэлтэй хүн ээ гэж бодож бас амжлаа.

-Галлаад! гэх даргын зандрангуй дуу хангинамагц буун дуу зэрэг зэрэг нирхийж, миний хэвтсэн довцог дээр аяараа хеделж, ойр хавийн шороо буцлан, газар тэнгэр нийлэх шиг болоход дотор муухайрч, зэвгэр бор хувцастай дайсан бүдгэрэн холдсоор харанхуй боллоо.

Гэнэт сэрвээнээс нэг юм угч татахад арай гэж нүдээ нээж харвал дарга дэргэд ирчихсэн

-Яаж байна? гэв.

-Яагаа ч үгвй, бие жигтэйхэн, яана аа даргаа

-Шархадсан уу?

-Үгвй дотор аягвйцээд... Та намайг дэргэдээ... гэтэл

-Бүү ай, тэр мелхеж байгаа дайсныг устга! Гээд мелхеед явчихлаа.

Дайсан руу буугаа онилох гэсэн чинь овоо хараа нь харагддаггвй. Барьсан мод үзэгдэхгвй мананд орчихсон юм шиг хамаг юм цэнхэртэн цийлэгнэнэ. Нэрэлхээд яаж вэ, үнэн нь тэр юм чинь. Хэвтэж хэвтэж жаахан уужраад харсан чинь хоёр нехер маань огт тэвдсэн янзгвй онь холбон буудсаар. Дайнд эр хүн шалгардаг юм гэнэ лээ. Ийм л улс гавьяа байгуулдаг байх. Баатар болно гэдэг чинь над шиг хүн зүүдэнд багтамгвй ажил юм гэж бодон нааш мелхеж буй дайсан руу хий л гелерсеер байв.

Гэнэт дайсны хэдэн хvн эргээд зугатлаа. Тэгэхээр нь эр хvн байна даа, буудъя байз гээд зориг орж хойноос нь хэд буудаж билээ. Одоо бодоход ниргэсний дараа хашгирах гэгч, нөгөө vгээр хэлбэл, сvнгvй хонь холбоосог гэдэг л тэр болжээ.

Бидний араас туслах хvч ирсэн юмсанж. Бид гурав зvв зvгээр. Дарга нар, найз нeхeд баатарлаг тулалдсан гэж биднийг магтана. Хожим ухаан ороод vзсэн чинь нээрээ л дайсны тэн хагасыг цааш харуулсан байж билээ.

Зоригтой эрэмгий тvмэн эрийн дунд над шиг мулгуу эр eдрийн од шиг байдаг биз.

Хань бараа л болж байсан байх даа. Тvннээс биш миний хувь нэмэр гэж юу байх вэ дээ. Тэр хоёрын л гавьяа юм чинь Гэгээн төрийн минь сvлд, сайн нeхдийн баатарлаг vйлс, ач гавьяа л амий минь аварлаа гэж халаглан vглэх шахаж, болж eнгөрсөн байлдааны бодохоос eвдeг чичрэн магнайны хeлс чийхран байлаа.

Ахлагч маань толгой сэгсрэн жуумалзаж аядуун зeелeн дуугаар,

-Мятав аа, дайтах ямар байна даа? гэлээ.

-Ярих юм биш дарга минь, арай л газрын хөрстэй хамт эргvүлчихсэнгvй гэж хэлэхэд хоолой чичирч, нvдний нулимс бvрхэлзэж байв.

Оройхон дарга нар бvх цэргийг жагсаан, болж eнгөрсөн тулалдааны тухай, манай эрэлхэг гурван нeхeр амжилттай байлдаж дайсны арав гаруй цэргийг устгасан тухай сонсгож, бидэнд баяр хvргэн хeхvүлэн шагналаа.

Би юу ч хороож амжаагvй хvн шvү гэж хэлэх гэснээ насных байсан юм бол уу даа, нeхдeсeе ичээд ам эвлэж eгeегvй юм.

Миний хувьд найман цагийн чeлeе хvнддэх том шагнал. Манай хоёрыг баатар болгосонгvй шvү. Ийм улсад eгeхгvй байгааг бодоход баатар болно гэдэг ч барагтай аавын хvү давдаг даваа биш юмаа. Би юу гэж бодож явлаа. Даанч ичгэвтэр юм бодож байжээ. Дур эзнээ голдоггvй гэгчээр мeн ч том санаатай явж шvү хэмээн eерийгeе зэмлэж байлаа.

Цэргvүд нам гvм унтжээ. Eдeр дайсантай тулалдсан хоёр нeхeр ч бусдын адил нэгэн жигд тайван хурхирна. Би элдвийг бодон хөрсөeсeр. Дарийн эхvүн vнeр, гашуун утаа хамар аманд шингeчихсэн, чих дvлийрэн шуугисан хэвээр.

-Yзээгvйгээ vзлээ. Төрийн минь сvлд гэж шивнэснээ “яана аа” хэмээн eерийн эрхгvй чанга хэлчихээд тvннээс айн цочиж бeндгeсхийснээ eх, eх яаж тайвширдаг юм билээ. Хvн яахаараа ийм их зориг зvрхтэй амгалан тайван байж болдог юм бол. Энэ хоёрын хурхирч байгааг.

Дайтаж эхлэхээр ч орох нvх сvв олдохгvй, яаж ч болдоггvй эд юм. Эрдэнэт хvний

амь хутганы ирэн дээр л байх юм билээ. Золтой хяргуулчихсангвй шvv. Дараагаар яаж харуулд гарна аа!

Дайсны буудсан сумыг нэг газарт л тусгадаг, хvнд болон биедээ хавьтуулдаггвй ид шидтэн ч болоосой хэмээн бодлогоширч хэвтсэнээ гэнэт нэг бодол тархинд харваж орлоо.

Тэгдэг хэрэг! хэмээн еерийн эрхгвй уулга алдан ендийгеед суучихав. Буцаж хэвтээд тvvнийг барьж явсан цагт дайсны сум биенд тусна аа гонж. Бvх сум тvvн дээр шавчихна. Сум чинь темер! Темер болохоор соронзон ховх сорчихоод байх нь гарцаагвй гэх мэт элдвээр эргэцvвлэн бодож, бодож,

-Ёстой ухаан ! Найман цагийн чөлөөг vвнд л зориулна. Тvvнийг маргааш олохдоо л олно гэж шивнэв.

Дайн тулалдааны тухай зvрх vхvүлсэн бодол хоног хоногоор замхран арилж байв. Хэд хэдэн удаа харуул манаад гарч, бас ч хоёр гурван удаа жижиг тулалдаанд оролцож, дайснаас ганц нэгийг цааш харуулдаг боллоо. Орж байх газар олдохгвй тэвдэн сандарч хеглеж байснаа бодоход хал дол vзсэн хуучин цэрэг болжээ. Эр хvн хэцvв бэрх цагт хатууждаг гэж vнэн шvv.

-Байлдагч Мятав тушаал хvлээн авахад бэлэн vv? Гэж хороон дарга свртэй асуухад,

-Ямар ч тушаал биелvүлэхэд байлдагч Мятав би бэлхэн! гэж хариуллаа.

Бид сая тагнуулын мэдээ хvлээн авлаа. Хэсэг дайсан хилийн ойролцоо ирж буудалласан байна. Хvн хvч зэвсэг техникийн тоог мэдэн, амьд хэл олзолж ир! гэж тушаахад,

-Мэдлээ, нөхөр хурандаа, гvйцэтгэе гэж ёсоллоо. Тушаал авахад бага vд болж байсан юм даг. Би заасан газрыг чиглэн явж барсгар хадтай толгойд нуугдан харанхуй болгохоор шийдлээ. Дайсны байрлалыг дурандвал хоёр машин цэрэг бололтой жар орчим хvн хоноглохоор шийдсэн янзтай оромж босгож байлаа. Оройн бvрий болтол эндээ хvлээхээс еер аргагвй. Тагнаж мэдэх, амьд хэл олзлох тухайгаа нэгд нэгэнгvй нарийвчлан бодлоо. Тийм ч амар vврэг биш. Яаж биелvүлдэг хэрэг вэ гэж удтал эргэлзэв. Олигтой юм санаад орж егдөггвй шvv.

Цаг дээрээ тулахаар учир нь олдоно биз гээд ширхэг ч vүлгvй цэлмэг хөх тэнгэрийг харж хэсэг хэвтлээ.

Ессен нутаг, аав, ээж, ах дvv, нутаг усныхан, хурдан явдалтай морьд, цэрэгд мордсон, хилд ирсэн, анхны тулалдаан цөм ээлж дараалан санаанд урсан орж ирнэ.

Гэнэт еерийн эрхгвй инээд хvрч,

-Нээрэн тэр нэг темер! Их ажил болсныг яана аа. Бараг едержин эрсэн шvv. Тэгсэн

хэрнээ хэрэглэдэггүй хэрэглээгүй нь ч болж, амьтны доог болж нэр нүүрээ хеедех байснаас зайлахгүй. Мөн ч тэнэглэж байжээ. Их айсных л байхдаа . Биендээ сум хавьтуулахгүй, соронзонд татуулна гээд түүнийг тэвэрчихсэн харайж байсан бол ч едийд муу Мятав олон даяар хөгсө дэлгэчихсэн байхдаг шүү. Цэрэг болгон л захиандаа бичнэ дээ. Аа-яа-яа гэж толгой сэгсрэн биеэ тавиртал хөхөрлөс.

Яахаараа тийм юм ухаанд орсон шүү болсон юм бол доо. Хүчтэй соронзон ч нээрээ бууны сум нь юу юм бэ, хэрийн төмрийг үлдээхгүй ховх сорчих байх шүү гэж бодтол гэнэт шинэ арга сонин бодол тархинд минь зурсхийн орж ирлээ.

-Ёстой догь. Яг болно. Хуу татуулна хэмээн би өөрөө мэдэлгүй дуу алдав.

Яаран явж, зориудын эрэл болж байж олсон “учиртай” төмрөө булсан тэмдэгт газраа очин тогоон тагны чинээ дугуй төмрийг малтан гаргаж ирээд түүнийг юунаас ч илүү нандигнан байлдаг эрийн ширүүн гараар энхрийлэх адил илж, “За хө чи бид хоёр ч тэднийг ганц болгож өгнө дөс. Яг болно!” хэмээн ганцаараа ярьж суулаа.

Дугараг том төмрөндөө бат бэх оосор хийлээ. Үүрч үзсэн чинь биенд эвтэйхэн байгаа гэдэг яриангүй.

-Оройн цагаан гэгээ тасарч, үдшийн бүрий болох үед би товлосон газраа аль хэдийн хүрч, дайсны байдлыг ажиглаж, чимээ чагнан хэвтэж байлаа. Шөнө дундын алдад тэд цөм унтав бололтой, таг чимээгүй боллоо. Хааяа чимээ өгч байсан манаач ч мөн таг чиг болов.

Дуу чимээ гаргахаас болгоомжлон мелхсөөр зуны айлын чинээ ирлээ. Амьсгаагаа дарж чагнахад нам гүм хэвээрээ. Хааяа хүний яраглах нь дуулдах бөгөөд цөм бөх унтсан шинжтэй. Нэг хүн босоогоороо үе үе дунхгас хийнэ. Тэр манаач нь бололтой.

Харанхуйд нүдээ дасгасаар ойртвол оромжны хойхно сарайж сэрийсэн юм харагдлаа. Бие биеий нь түшүүлээд тавьчихсан буу байхыг үзээд, хэрэг болбол ганц ухасхийгээд л нэг дор тавьсан зэвсгээ төвөггүй авах нь байна шүү. Айхтар мондинууд гэм. Энэ чинь надад л сайн хэрэг. Амттай хоол бэлтгээд тавьчихсан л гэсэн үг. Эдгээрийн минийх гэж тооцье. Салгаад авчихсан хойно тоо нь аяндаа мэдэгдэнэ.

За даргын тушаал чинь хүн, зэвсгийн тоо, амьд хэл...

Өдөр тоолоход яг л жаран гурван хүн байсан. Энэ болно. Бууны тоог мэдэх төдийгүй цөмийг нь... Хамгийн хэцүү юм амьд хэл! Яах вэ байз. Энэ үүрэглэсэн манаачийг л эрхэндээ оруулах хэрэгтэй, чухам яаж өөрийн болгох вэ. Мелхөж очоод дуу гаргалгүй бариад авна гэж бодье: Үгүй ээ. Тэгэхээр өгсө чухал юмаа үүрэхийн оронд аманд нь алчуур чихэж, хөл гары нь хүлсэн хүн үүрэх болно. Ингэж болохгүй ээ, миний ачаа өрдөө хөнгөдөхгүй . Яая даа байз. Эр хүний дотор

эмээл хазаартай морь багтдаг гэдэггүй билvv. Ганцхан л арга хэрэгтэй сэн гэж еереее ухаан шаардаж хэсэг ажиглалаа.

Гэнэт манаач буугаа барьсан юм уу, мөрлөсөн vv, vүрсэн vv гэдгийг мэдэх хэрэгтэй боллоо. Ялигвй ойртоод харвал vүрэглээ манаач буугаа бvр лав vүрчихсэн, тvvгээрээ тvшиг хийгээд ганхаж ч байгаа юм шиг.

За, хэргээ бvтээж болно. Одоо шийдсэнээ хийх цаг боллоо гэж бодсоор босож зогслоо.

Мятав минь одоохон эхлээч гэх шиг эх нутгийн зvгээс урьхан салхи сэвэлзэнэ.

Догдлон байгаа сэтгэлээ дарж, бодсоноо хийхээр шийдэж оосрын нь шалгаад соронзонгоо vүрлээ. Татдаг талы нь сарайж сэрийсэн беен бараан юм руу харууллаа.

Мод төмөр харшилах төдийхөн чимээ гарснаа енеех олон буу хоромхон зуур ирж соронзонд минь наалдчихлаа. Сарайж сэрийсэн бараан юмны оронд овойж торойх хумсын чинээ л юм vлдсэнгvй. Ховх сорчихжээ.

Юу ч болтугай цемий нь гарыг мухарлалаа.

Одоо манаачийг нь соруулах цаг болж гэж шийдээд цаашаа хараад дунхаганаж байгаа манаач руу соронзонгоо харуулав.

Бич ангийнхаа зvг шогшиж гарлаа. Ачаа vүрэг ч зэгсэн хvнд болжээ. Эргэн харван манаач эрийн буу соронзонд аль хэдийн наалдчихсан эзэн нь бууныхаа оосрыг мултлах санаатай сарвалзаж байлаа. Бас цаашаа зvтгэж vзэж ч байгаа бололтой.

Манаач арга нь барагдсан бололтой муухай ориллоо. Тэр дуунаар дайсны цэргvүд шулганалдан хашгиралдаж эхлэв.

Би ч тvvнд бууныхаа оосроос мултрах завдал егелгvй явдлаа арай хурдатгаж байлаа.

Дайсны муухай орлилдож хашгирах чимээ бvр холдсоор. Гахай явган, нохой нvцгэн барьсан модгvй тэд яав л гэж дээ хэмээн инээд хvрч байж билээ.

Хvн гэдэг амьтан айхтар шvv ! Негее манаач чинь орилж нэг vзнэ. Зvтгэж нэг vзнэ. Сарваганаад л байгаа бололтой. Ярдаг эр байж билээ. Ар тийшээ татагдаж яваа хvн чинь унахгvйг хичээж зөвхөн тэнцэж байхын хvслэн болж явдаг юм билээ. Эргэх гэхээр уначих гээд яаж ч чадахгvй явааг би бvр тvрvvнд мэдсэн юм.

Тэр буугаа давчуу оосортойг мэдэхгvй даанч лав vүрсэн байсандаа л миний олс болсон юм. Есехеее морь уургалсан би едер туршин vзэж байхдаа яаж ч улавчилж суугаад тогтоогоогvй юм. Ийм айхтар хvчтэй татагдахыг анх удаагаа vзэж байгаа хvн ч яаж тогтоох вэ дээ. Тэгэхдээ тун хөл сайтай эр байсан санагддаг юм. Муухан эр бол муухай орилоод хvржигнэтэл чирэгдэж ачааг минь хvндрvүлэх

байсан. Тэр тэгээгвй юм шvv

Би соронзонгийн гайхамшигтайд урамшин зоригжсоор баяр хеертэй, их олз омогтой ангидаа эсэн мэнд ирж, тушаалыг ёсчлон биелvvлснээ даргадаа илтгэсэн юм. Цэрэг, цэрэг чигээрээ тердеггвй гэдэг vнэн юм шvv.

Би Элзий гуайн зааснара сураглаж явсаар хоньчин Менхтэй уулзлаа. Тэр едер Менх гуайн хонины ээлж таарчээ.

Намхан цэнхэр уулсаар эргэн тойрон хvрээлэгдсэн ерген хендийд хойд биед байх ухааг бvрхэн соргог сэмvвн бэлчээрт хонин сvрэг тавтай идээшлэнэ. Тэнvвн талын дундах холбоо нуурын захаар адуу мал багшран бараантаж vзэгдэх бегеэд тэндээс нэлээд зайдуу байх цагаан гэрvvдийн яндангаас шингэн цэнхэр утаа баагиж, гvвн зэл орчимд унага даага тонгочин давхилдана.

Голын эрэг даган хэд гурваар тархан буусан айл саахалтын хооронд морьтой багачууд хендлен гулд давхилдаж хаа нэгтэйгээс vхэр меерен дуу янцгаах нь хvvхэд багачуудын цовоо шингэн дуутай хослон сонсогдоно.

Энэ бvхнийг сониучлан цэвэр цэнгэг агаар, тvмэн зvйлийн ургамлын vнэр танарыг таашаан явах юутай бахтай. Ай тэнvвн жаргалант тvмэн амгалан монгол эх нутаг минь. Цагийн сайхан дэлгэр зуны эхэн сар, газрын сайхан хедее нутгийн уужим хендий.

-Та Мятав гэдэг хvнийг таньдаг уу? гэж Менх гуайгаас асуулаа.

-Адтай Мятав гэж нэг танил бий. Аавын цээж Мятав ч гэж бас бий. Аль нь юм бол доо?

-Мэдэхгвй, их эртэй, зоригтой, лут сэдээч, ухаалаг хvн юм гэнэ дээ.

-Сє тэгвэл адтай Мятав гарцаагвй мен. Тvvнтэй дvйх арга ухаан, авхаалж самбаатай аавын хvv ч ховор шvv. Сєдлехед санах сэдэх гэж vг байдаг даа. Тvvнийг бvрэн эзэмшсэн хvн бол Мятав л байгаа юм.

-Та тэр хvний явдлаас ярьж егехгвй юу?

-Би мэддэгээ ярьж ч болно оо, чи юу боловч Эрдэнэтэй уулзаарай. Тэр Мятавтай нийлж олон жил ан герее хеесен хvн дээ. Санаанд хэд гурван юм бий байх. Хvv минь, Свєр жаргалантыг мэдэх билvv? Тэднийх тэр хавьд л байгаагаас зайлахгвй гээд хэсэг бодлогоширсноо

-За даа би ч тун мунгинуу хvн дээ. Бодоод байхад тvvний ярьснаас хоёр гуравхан юм ухаанд минь vлджээ.

НЭГ СУМААР ХОЁР ЧОНО

Мятав цахиур буугаа үүрчихээд нэгэн халуун едер уулын хэцээр харж явжээ. Чулуу хвртэл данхтай халуун цайд гараа хвргэсэнтэй адил улайдсан жин үдийн халуун болов.

Морио чедерлечихеед хадан дэл дээгүүр энгийтел ойролцоохон хоёр том чоно халуун наранд нам цохиулсан мэт тэрийн хэвтэж байлаа. Хар авахуулчих вий гэхээс буцаж болдоггүй, байж болдоггүй яг гацчихлаа.

“Буруу газраас л энгийчихлээ. Тэр зүүн дэл дээрээс гарч ирсэн бол нэвт буудчихад болохгүй гэх газаргүй юм. Яадаг хэрэг вэ, зүүн дэл еед мелхдөг юм бил үү? Яршигтай юм даа, энэ халуунд, ...Нэгийг нь буудахаар негеег нь алдчихна. Цахиур буу цэнэглэх хооронд хэдэн уул даваад талийна” гэж бодлоо.

Тэгснээ халуун наранд элгээ маарштал дэмий хэвтэж байхаар хоёуланг зэрэг агнах арга сүвэгчилдэг хэрэг ээ гэж ажиглаж гарлаа. Гэв гэнэт тэмээний хорголын чинээ бөв бөөрөнхий чулуу хоёр чононоос наахна тэгэхдээ нэгэнд нь нэлээд ойрхон байгааг үзэж аргаа дорхноо оллоо.

Юу ч гэсэн мууижртал нь дэлсчихмээр овоо шаг хийсэн эр чулуу боллоотой. Сарьсан хоншоор дээр нь тааруулсан байхад ч учир бий. Суманд бол огт санаа зоволтгүй. Замдаа нэг хвч аваад л хулхиар нь орчихно.

Нар тусаж байгаа тэр гялгар бөөрөн дээр бол “нимгэднэ” Наад бараан хэсэгт баривал “зузаадна” Тэр гялгар бөөрөнхийн наад амсарт бол яг таарна. Сум бөөрөнхий, чулуу бөөрөнхий! Бильярдаар бол яг л хоёр буланд гэсэн үг.

Товлосон газраа шагайн гохоо атгалаа.

Шаг хийх яхир чимээ дуулдсанаа пүд, таг хийх дуу зэрэг гарч, хоёр чоно умираад явчихлаа.

Чулуунд оногдож муужирсан чононд гүйн хврч, муу хийж аваад негеедех дээр нь ирвэл сум яг хулхинд нь туссан байжээ.

Мятав ингэж нэгэн сумаар хоёр чоно агнаж, ганзагаа мялаасан удаатай. Ангийн тэнгэртэй яваа хүнд ч арга ухаан дорхноо олддог юм билээ.

УТАС ОЛСНООС ХҮЧТЭЙ

-Мятавын явдлаас үзсэн еер юм байна уу Мөнх гуай?

-За даа еер юм үгүй шив дээ.

-Ингээд л болох гэж үү?

-Харин ээ юу сан билээ. Аа тийм. Манай муу идэмхий солби шарыг... гэж тодхон

хэлээд инээн ингэж ярилаа.

Хэдэн жилийн өмнө юмсан. Манайх нvvж явлаа. Свeр Жаргалантын голоор нvvдэл маань гарах болов.

Хэсэг, хэсэг булагнаж ногоорон эргэлдсэн хэцvv бэрх тохой цvнхээл элбэгтэй энэ голыг гармы нь олж гарахаас биш дуртай болгон санааныхаа зоргоор гаталж амждаггvй билээ.

Ачааны тvрvvч голын нөгөө эрэг дээр гарч байтал цаанаас Мятав хатирдаг хээрийг уначихсан хvрч ирэв ээ. Амар мэндээ мэдэлцээд:

-Хаа хvрээд буцаж явна даа гэж асуувал

-Агентынд очиж аахар шаахар юм аваад л явж байна гэлээ. Ачааны хамгийн сvvлд явсан, хоёр хөхvvр айраг ачсан солби шар тайлаг голын тэг дунд орж ирснээ бурантгаа тасдуулан сууж vлдээд,ийш тийшээ харж байснаа ингээд л дvvрье гэсэн аятай муухай орилон дайвганасаар ойчоод өглөө.

Амы нь сайн боож тэгнэсэн хөхvvртэй айраг усанд живч орохгvй байгааг шар тайлаг доошоо ч ордоггvй, хеллөөд босож ч чаддаггvй өөдчихсэн бололтой, аврал гуйсан нvдээр биднийг ширтэн сэвсээрээ булан орилсоор усны урсгал даган хөвж эхэллээ. Ачаатай тайлаг гарамнаас аль хэдийн ходож ойртон очиж болохооргvй, ус нь ногоорон эргэлдсэн том цvнхэлд хvрч, наашаа ч vгvй, цаашаа ч vгvй болоод усны эргvvлэг даган өөрийн эрхгvй эргэлдэн хөвсөөр. Би хий бухимдан:

-Ээ, малын шаар! гэж хараал тавьж, хөж! хөөг! хэмээн дотроо дэвслэн хичнээн хашгичсан боловч огт нэмэр болсонгvй.

Мятав:

-Тэмээ усанд мууг хэлэх vv, энэ одоо босохгvй ээ! Эргvvлгэнд орчихож, гарч ирэх горьдлого тасарлаа л даа гэв.

Би яадаг ч аргаа олохгvй, улам цухалдаж,

-Ийм дvvрсэн мал гэж байдаг аа. Бусад нь гармаар давгvй гарчихаж байхад... Даавуу хэмлэхээс өөд идгvй, заяагvй мал байх гэж яая даа та минь, Дvvрлээ л дээ гэтэл Мятав:

-Энэ чинь тийм их идэмхий мал юм уу? гэлээ. Би ч тэр тайлгийг муучлахад vг хайхралгvй гэсэн шиг.

-Яриа юу байх вэ? Дvvрчихсэн идэмхий золиг байгаа юм. Энэ яваа насандаа уранхай тасархай даавуу урдуураа зvгээр өнгөрөөж огт vзээгvй амьтан! Тэмээ сэжигч амьтан, харин vвнд эрээлэх юм гэж даанч байхгvй дээ! хэмээн хэлж

орхилоо.

Мятав “Сөр аргагвй” гэж шийдмэг хэлэд өврөөсөө оёдлын машины утас гаргаж нэлээд хөвснөө тэрэгтэй уснаас тэмээ рvv шидээтэхлээ. Тэрэгтэй улаан утсыг дэргэдээ буунгуут идэмхий шар ч мэргэжсэн минь энэ гэсэн шиг үмхээд авах нь тэр.

Яаж байгаа юм бол доо гэж гайхшаа баран ажиглаж зогстол Мятав утасныхаа үзvvрээс угз татан цааш алхлаа. Идэмхий шар тайлаг ч хөвсөн янзаараа чирэгдэж эхлэв. Мятав нилээд явж тогтуухан ногоорон эргэлдэгч эргvvлэгт тохойноос орлио шарыг гаргах зуураа голын эргийг няхуур ажиглаж байгаад усны урсгал серген гарамны зvг ачаатай тайлгийг дураараа хөндлөн гулд чирж гулдарч явлаа.

Идэмхий шар тайлаг учрыг олоогвй хэрнээ таатай байгаа янзтай, хялгас төдий вл ялих нарийхан утсанд ачаа бараатайгаа цуг чирэгдэн, усны урсгал серж яг л усны шувуу аятай хөвж яваа үзэгдлээ.

Миний гайхсаныг хэлээд баршгвй. Гараад ирлээ шvv гэж бодохоос баярласан гэдэг учиргвй.

-Үгвй мөн хачин аа! Муу солби шар минь элдэв даавуу шуувуу влдээдэггвй хамж иддэг үнэн идэмхий амьтан гэсэндээ тэрэгтэй утсыг овоо үмхэж шvv гэж үглэл бухимдал маань инээдээр солигдов.

Солби шар тайлаг уснаас гараад юу болов доо гэсэн маягтай усаа сэгсэрснээ аманд орсон дээр нь... гэсэн шиг тэрэгтэй утсыг ховдоглон хвлхсээр бусад тэмээ рvvгээ очиж билээ.

-Үгвй бас хачин юм даа. Мятав аа, тайлган тэмээг ачаа бараатай нь хамт оёдлын машины утсаар чирж их уснаас гаргана гэдэг санаанд багташгвй юм шvv. Алив наад утсы чинь үзье гэвэл Мятав нэг их гоц гойд юм боллоо гэж бодсон янзгвй.

-Үз л дээ. Юм оёдог жирийн л утас шvv дээ гээд надад утасныхаа нэг хэсгийг төвөггвй тасдаж өгснөө

-Усанд хөвсөн бие их хөнгөрдөг гэж ярилцдаг байх аа! гэж байсан юм шvv.

Биеийн тамирын ордны ергөн цэлгэр танхимд хvmvvc пиг дvvрсэн байв.

Таван ханатай гэрийн буурийн чинээ дэвжээн дээр өндөр гулзгар хvн, намхандуу лагс биетэй залуу хоёр ач тач ноцолдон дээр дороо орж годройтон дунгуйлдан боловч хэн нэг нь оноо авч чадахгвй байлаа.

Нэг нь өрсөлдөгчөө өргөөд чулуудсан чинь нөгөөг нь унахдаа хелийг нь хаман дарж ойчлоо. Өндөр гулзгар эр ганц горьдлого маань энэ боллоо гэсэн мэт байдаг чадлаараа нумлалаа.

Намхан нуруут ч ийм болгоод алдчих вий гэсэн янзтай анаж, байдаг чадлаараа дарсаар. Среесен дал нь дэвжээнд хврлээ.

-Уухай дараад бай, дараад бай хэмээн танхим дүүрэн шуугиан боллоо.

Сеедсен мэт хэвтээ залуу шүд зуун гэдийж, дээр нь байгаа эр байдаг тамираа шавхан цээжээрээ дарсаар... Дарж даруулж байгаа шинжгвй огт хедлелгвй хвч нь яг тэнцэн нэг л хэвэндээ. Цагаан хувцастай шүүгч хэрхэхийг отон цаана нь ажигласаар. Олны учир тоймгвй шуугиан үргэлжилсээр. Гэнэт хурган дотортой хүрэн торгон дээлтэй ануухан евген суудлаасаа босож,

-Дараад нэмэргвй, тэнхээний гарз. Хелий нь солбиод гэж хуруугаараар зааж хэллээ.

Бех ч санаа авсан мэт баруун хелнийх нь доогуур гараа хийж цаад хелнеес нь зугуухан татлаа.

-Зев, зев. Одоо цээжээрээ сайн дар! гэж енеех евген хашгирна.

Шүгэл тасхийн, учиргвй шуугиан нижигнэсэн алга ташилт болж хувирлаа.

Тэр евген чинь хэн сэн билээ, үзсэн хвн шиг. Унжуудуу хамар, урт эрүүтэй, сэргэлэн хурц нүдтэй, амьдралын олон он жилийн хугацаанд хал дол үзсэнийг гэрчлэх мэт хэдэн гвн үрчлээ суусан ерген сайхан магнай, тэгш сайхан шүд бүхий, цээж тэвхгэр зузаан, залуудаа сайхан эр явсан болов уу гэмээр янхигардуу чацархаг биетэй, хенген шингэн, нүдэнд дулаахан сайхан евген байх чинь. Хаана үзлээ?

-Аа тийм. Мятав гуай байна. Яг дүрээрээ мөн гээд би тэр хвн рvv олны дундуур дайрлан зүтгэлэв. Хвн амьтан замд тээглээд ер явж болдоггвй.

Нэг харсан чинь Мятав гуай бах нь ханасан янзтай инээж хажуугийнхаа хвнтэй ярилцсаар хаалгаар гарч явлаа.

-Хее Мятав гуай гээд би байдаг чадлаараа хашгиртал

-Сэрээрэй залуу минь гэсэн бүдvvн баргил дуу гарч, хенжлеес татаж байлаа. Би зүүдэлжээ. Хайран зүүд гэж харуусан ендийтел ечигдер эрэлд яваад ирээгвй байсан Эрдэнэ гуай аль хэдийн хувцаслачихсан цай уун сууж байв. Би нэгд зүүдэлж хашгирсандаа, хоёрт Эрдэнэ гуайг шене ирэхэд нь сэрээгвйдээ бантан ичингвйрхэн шуухитнан хувцаслалаа.

-Аль хар амрав даа. Арай эрт сэрээчихэв vv дээ. Цай уу гээд Эрдэнэ гуай миний емне тавагтай ерем тавьж цай аягалж еглес.

Эрдэнэ гуай цай уух зуураа:

-Счигдер хэдэн тэмээгээ харж гадуур жаахан яваад олсонгвй. Снеедех дахиад л

шогшихоос доо. Манайхан чамайг надтай уулзахаар ирсэн гэж ашгвй надад түрүүхэн хэллээ. Золтой л унтаагаар чинь орхичихоод мордоод явчихсангвй гэм. Хот газрын хүнийг хэлэх үү, нас залууг хэлэх үү, нойртой байлгвй яах вэ гэж миний сантаж байгааг мэдсэн янзтай хэллээ.

-Би танаас ганц нэг юм асуух л гэж ирсэн юм. Та яаруу ажилтай байгаа бол хамт мордоод замдаа яриулсан ч болох л доо гэж намайг өгүүлтэл:

-Хүн уулзахаар зориуд ажил болж ирж байхад хаанаас тэгж болох вэ? Ах чинь хэрэгтэй бол хэдэн тэмээндээ маргааш явсан ь болох шүү дээ гэлээ.

-Ялтай ч юм биш ээ гэж би түгдэрснээ:

-Та Мятав гэдэг хүнийг таньдаг гэл үү? гэж асуув.

-Ямар Мятав?

-Адтай Мятав

-Танихаар барах уу даа...

Эрдэнэ гуай босож айргаа бүлснээ шуугин байгаа хөхүүртэй айрагнаас хувинд уудлан өмнө минь тавив.

Би сэнгэнэсэн сайхан айрагнаас аягалан залгилж,

-Та Мятав гуайн ажил явдлаас надад ярьж өгөөч гээд учирсан хүмүүс, тэднийг ярьсныг товч хэлэхэд Эрдэнэ гуай:

-Үнэндээ хеерхий, яг л тэгж ярьдаг юм.

-Чи еертэй нь уулзахыг бодоорой. Охин хүү хоёроо дагаж хөгшинтэйгээ хот ороод хэдэн жил болж байгаа юм. Мятавын ярьснаас би хоёр юмыг нь л сайн санаж байна. Түүнийг түрүүчийн улс чамд яриагвй боллолтой. Миний хувь болгож үлдээсэн юм байлгвй дээ гээд инээв.

-Ээ дээ, түүнийгээ л гэж би дуу алдав.

МЭХЭЭРИЙН АМТ

Хэдэн хурга шингэнээр гүйлгээд болдоггвй. Мэхээр сайн юм гэнэ гэж дуулаад Мятав ойд очиж, оготно хөөлсөн жаахан мэхээр олоод, багадуулж хэлбэл үдийн газар, бадруулж хэлбэл хоногийн газар ирсний хэрэг юу билээ, ахиухан байвал зүгээр ч юм уу гэж санан ой дундуур хэрэн бэдэрч явжээ.

Тэгсэн чинь нэг их том баавгай идэш хайсан янзтай огт сэжиг авалгвй явж байгаа

взэгдлээ. Яадаг хэрэг вэ? Буу ч байна, сум ч байна, цааш харуулчихдаг хэрэг үү гэж хэсэг эргэлзлээ.

Мориноосоо буун буугаа шийрлэх зуур энд нь нударчихаж болно. Харин түүнийгээ яаж гэр еедее дехүүлдэг хэрэг вэ? Алахаасаа елгөх нь.... гэсэн бодол орж ирлээ.

Нээрээ тийм, бараг сум сунган аймаг алгасан гэр орноосоо зайдуу яваа ганц хүн энэ том амьтныг алахад амины нь гарз юм гэж эргэлзэн буудахаа болилоо. Яаж гэр еедее дехүүлье дээ. Туултай биш, дуудалтай биш хэмээн санаж санаж нэг арга олов.

-Гарцаагүй бүтнэ гэж шивнээд шалавхан мордож баавгайг амдлаа.

Үүгээр л ирнэ шүү дээ гэж бодон ойн нэгэн цоорхойд мэхээртэй хүүдийгээ энд тэнд нь жижигхэн жижигхэн тэгэхдээ гоожчихооргүй цоочлоо.

Ганзагалж явсан арваад алд сурныхаа үзвүрээр амы нь сайн боочихоод хол оо очиж, нөгөө үзвүрээс нь барин тэр том амьтны хэрхэхийг ажиглаж байлаа. Баавгай явсаар нөгөө ойн чөлөөнд ч гарч ирлээ. Ер сэжиг авсан янз алга аа! Үзэхгүй явчихна уу даа, энэ монди чинь гэж шивнээд хэсэг харлаа.

-Алхаад өнгөрөх нь шүү. Баавгай ижилгүй тэнэг гэдэг нь үнэн болж таарлаа гэж бодуут сурнаасаа жаахан жаахан угзчив.

Баавгай гэнэт зог туслаа. Амь голтой юм шиг татав, татав, ухас ухасхийж байгаа тэрхүү ер бусын “амьтныг” сонирхсон эгдүүцсэн янзтай ширтэж байв. Мятав ч угзчихаа больжээ... Баавгай адтай хөдөлж байсан хачин “амьтан”- хүүдийг гайхсан янзтай ажиглаж, залхуутай тэгэхдээ хянуур нь аргагүй түүнд ойртлоо. Бүр очоод шинжиж гарав аа. Тэгснээ хүүдийг долоож эхлэв. Сайхан амттай хоолтой учрав гэсэн янзтай ийш тийшээ харснаа ум хумгүй долоолон хэл амаа билүүдэх нь аргагүй дуртай юмтайгаа учирсныг гэрчилнэ.

Болдогсон бол бүхлээр нь залгичихмаар байгаа бололтой. гэвч аманд нь олигтой өм орж өгөхгүй байгаа янзтай хий л нухчин тунтаганана. Одоо амты нь бүрэн авах шиг боллоо гэхтэйгээ зэрэг Мятав хүүдийтэй мэхээрийг угз татсан гэнэ. Баавгай амттай хэрнээ “амьтай” хоол гэж байдаг байж дээ гэсэн янзтай цочсоноо хүүдий рүү ам хамраа шилэмдсээр очиж бас л долоолов. Удвал, хүүдийгий нь хүн татчихаад аль ч үгүй болно. Баавгайд тухлах чөлөө өгөхгүй юм шүү гэж бодон сурнаасаа угз татав. Бас л хойноос нь айсуй.

Мятав ч гэрийн зүг өргүүлсээр, баавгай ч хүүдийтэй мэхээрийн хойноос шогшсоор. Ёстой барахгүй цадахгүй хоол гэдэгтэйгээ тэр баавгай учирчээ. Ойртож ирээд долоотол гэнэт годхийн алга болно. Амттайг нь бодвол идэж барж салахаас нааш санаа амрахгүй гэсэн янзтай хүүдийтэй юмтай өнөөх баавгай хөөцөлдсөөр.

Нар хүүшлэхийн алдад баавгай, хүүдийтэй мэхээр Мятав гурав гэрийнхээ урд модтой толгойд хүрч иржээ.

Хэдэн хурганд жаахан юм үлдвэл харамлаад ч яах вэ идвэл идэг, гэрийнхээ хаяанд ч ирлээ гэж бодоод бууж, буугаа эхэллээ. Баавгай, баригдаж өгөхгүй зовоосон хоол тогтсонд санаа нь амарсан бололтой, өнөөх хүүдийг хүү татан амаа олохгүй үмхэлж эхэллээ. Срейдмеер гэнэн ч амьтан юм уудаа. Алж хядахын дон туссан биш, гэм тариагүй амьтан шүү дээ энэ чинь. Буудалгүй орхичихдог ч юм билүү гэж бодож байтал мэхээр нь барагдсан ч юм уу, хорхой нь дарагдаж ухаан ороод хажууханд нь хүн байгааг гэнэт олж үзэж зөвүүцсэн ч юмуу, муухай архираад дайрах гэжээ. Тэгмэгц Мятавын санаа шулуудан түүнийг буудан унагав. Хаа байсан алсын хяраас хаяандаа тийм том ан дагуулан авчирч эд бад хийснийг хүмүүс нүдээрээ үзэж байж арай гэж үнэмшсэн билээ.

ХЭШҮҮРГИЙН ЭРДЭМ

Ойрд үзэгдэхгүй хэдэн морио харах, бас ч малгайнхаа үсийг сэргээе үү гэж Мятав Батхаан ууланд гарсан юмсанжээ. Бараг цаггалан оготно шургаж багтамгүй шигүү ойд модны мөчиртэй ноцолдсоор яваад нэгэн хэсэг чөлөөнд гарч иртэл хүний давчидсан муухай хашгирах дуу, модны мөчир шажигнан хугарах чимээ гарав. Эргэн тойрон юу ч алга. Хүний хашгирах дуу ойртсоор. Хариу чимээ өгчээ.

Модны мөчир гишүү тас нясхийж байснаа дээрээс нэг хүн ум хумгүй харайж яваа харагдана.

-Амь авар! Зэрлэг гахай! гэж өнөөх хүн хашгирсаар наашаа байдаг чинээгээрээ харайж байв. Ойн хэсэг чөлөөн цаад шигүү мод ярагдан зугтсан хүний замаар нэг том гахай гарч ирэв ээ!

-Хэрэг бишидлээ яадаг билээ. Гар хоосон хүн зэрлэг араатны өөдөөс ямар хариу хийдэг хэрэг вэ? Харсаар байж эрдэнэт хүнийг зэрлэг араатны аманд өгч яаж болох вэ гэж Мятав гайхшаа баран бантаж зогссоноо, эргэн тойрноо харав. Гэтэл нэлээд урт барагцаалбал дөрөв таван алд хэрийн овоо бядтай сургааг хэвтэж байлаа. Бас л гэнэт нэг санаа тархинд нь харван орж иржээ. Түүнд учиргүй олзуурхан “дэр,дэр” гэж амандаа шивнэн ийш тийшээ харав. Хажууханд минь бүдүүн гээчийн салаа мод харагдлаа. Модны ац овоо өндөр ханын эрсийн дайтай байсан санагдах юм. Хүн гахай хоёр модонд тээглэхгүй болохоор аль аль нь байдгаараа хурдалж байгаа бололтой. Ус уух хувьтай хүн юм даа. Хүний үр ялгаа юу байх вэ хөөрхий, хийморьтой л явна шүү хэмээн баярлаж:

-Наашаа чиглээд гүй! харайгаад бай! гэж хашгирлаа. Өнөөх хүн ч амь тэмцэн харайсаар айлын дайтай ойрхон ирлээ. Мятав,

-Битгий сандар! Энэ сургаагны үзүүр дээгүүр харайгаад гар! Хол битгий явчихаарай гэж хашгирлаа.

Өнөөх хүн ч амь авах эцсийн арга энэ гэсэн шиг улаан гүйхээрээ ирж заасан ёсоор нь сургаагны үзүүр дээгүүр эрчээрээ харайлаа. Том бодон ч аманд орсон олзыг

алдахгүй гэсэн шиг хар хурдаараа айсуй.

Мятав биеэ харагдуулахгүйг хичээн модонд таширлан зогсоод, сургаагны их талын үзвүрээс барин анаж байлаа.

Бодонгийн урд хоёр хөл сургаагны нөгөө үзвүр дээгүүр гарч ирэнгүүт л барьж байсан үзвүрээ байдаг чадлаараа огцомхон нь аргагүй, газарт шигдтэл дарчихсан чинь хүчтэй хешилтенд ертегдсэн өнөөх бодон эргэлдсээр дээшээ хөөрч гарчээ. Ончий нь тааруул хөшсөнийх юм байх даа, хөөрөөд л байж. Нэг харсан чинь бүр дээр гарчихсан бараг л хомоол шиг жижигхэн хар юм харагдаж байсан гэнэ.

Удаж удаж бодон доошилж, яг л харвасан сум шиг юм бууж ирэхэд газар лүг хийн доргих шиг боллоо. Тэр том биетэй амьтан толгойгоор газар шааж унасан бололтой, толгой нь бараг цээжиндээ орчихсон байжээ.

Ингэж тэр хоёр хангай дэлхийн хайрласан хишгийг санамсаргүй хүртэж, том ангаар ганзагаа мялаажээ. Эр хүн гэдэг чинь эрээрээ сүрээрээ, ухаанаараа хээрийн догшин хэрцгий араатны сүр сүлдийг зайлуулж явах учиртай юм гэж Мятав ярих дуртай.

ДАХИАД Л ТОМИЛОЛТ АВАХААС ДАА

Миний томилолтын үр дүн энэ. Эрэл маань урагштай бүтэмжтэй байгаад олзуурхсаар нийслэл хотдоо буцаж ирлээ.

Эрдэнэ гуайн зааснаар баримжаалж, адтай Мятавынхыг сураглаж явсаар тав дахь хоногийн өглөөгүүр орон сууцны шинэ хорооллын тохилог байрны нэгэн хаалгыг тогшив.

Хананд янхигардуу чацархаг бие, унжуудуу хамар, урт эрүүтэй, делгөөн сайхан нүд, хэдэн гүн үрчлээ суусан ерген саруул магнай бүхий ухаалаг байрын нүдэнд дулаахан сайхан өвгөний зургийг хүндтэй байрлуулжээ.

Тэр гарцаагүй адтай Мятав мөн! Би Мятав гуайг нэг л ер бусын хүн байдаг болов уу гэж төсөөлөн бодож явсан юм. Гэтэл санаснаас огт өөр, хүн хүнээс онцгойрч ялгарах юм даанч үгүй, ёстой л хамгийн эгэл жирийн хүн байлаа.

Хаалга тайлж, тохилог аятай гэртээ урин оруулсан телев сайхан эмэгтэй ч яг аавыгаа дууриаж тержээ.

-Танай аав чинь Мятав гуай бил үү?

-Тийм ээ

-Аа ашгүй, би уулзах гэж ирсэн юмсан.

-Аав енєє еглєє дүүгийнд очихоор Євєрхангай аймаг руу онгоцоор явчихсан шvv дээ гэсэн уриалагхан намдуун дуу намайг балмагдуулав.

Дахиад л томилолт авахаас даа

1980 он